



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 22 өдөр

Дугаар А/620

Номгон

Г Ерөнхий боловсролын лаборатори Г
“Номундалай” цогцолбор сургууль үүсэж
хөгжсөний түүхт 100 жилийн ой тэмдэглэхийг
зөвшөөрөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Монгол улсын Засгийн газрын 2019 оны 204 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралтаар баталсан “Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх журам”-ын 1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баянхонгор аймгийн Ерөнхий боловсролын лаборатори “Номундалай” цогцолбор сургууль үүсэж хөгжсөний түүхт 100 жилийн ойг төгсөгчид , багш нарын саналыг үндэслэн 2024 оны 05 дугаар сарын 18-ны өдөр тэмдэглэхийг зөвшөөрсүгэй.

2.Ойн арга хэмжээг тогтоосон хугацаанд зохион байгуулалтын өндөр түвшинд тэмдэглэж улс, аймгийн хэмжээнд иргэд олон нийтэд сургуулийн үйл ажиллагаагаа сурталчлан таниулж, бүтээлч, шинэлэг хэлбэрээр зохион байгуулж үр дүнг тайлагнахыг Номундалай цогцолбор сургуулийн захирал (Ц.Алтангэрэл), Боловсрол, шинжлэх ухааны газар (Ж.Алтанцэцэг) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Батсуурь), Нийгмийн бодлогын хэлтэс (В.Наранчимэг) нарт даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

642311645